



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/231

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны ээлжит цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах эрүүл мэндийн оношлуурын зардалд 2,903,850 (хоёр сая есөн зуун гурван мянга найман зуун тавь) төгрөг, цэрэг хүргэх шатахууны зардалд 924,520 (есөн зуун хорин дөрвөн мянга таван зуун хорь) төгрөг, нийт 3,828,370 (гурван сая найман зуун хорин найман мянга гурван зуун дал) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 3,828,370 (гурван сая найман зуун хорин найман мянга гурван зуун дал) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

